

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газрын Нийгмийн халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

СБА-2022/174/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт

2022 он

Тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 70518369

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 70512123

Аудитор:

Утас: 70512127

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

А.Мөнхцэцэг

Цахим хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
3. Аудитын тайлан.....	6
3.1 Ерөнхий зүйл.....	6
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	7
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	8
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	8
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын санал дүгнэлт



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.᠐᠗.᠒᠘ № ᠒3
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.ГЭРЭЛБАДРАХ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>604,051.82</u>	<u>0</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	604,051.82	0
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	604,051.82	0
3121	Төгрөг	604,051.82	0
31213	Арилжааны банк дахь харилцах	604,051.82	0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>604,051.82</u>	<u>0</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>604,051.82</u>	<u>0</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	604,051.82	0
512	Хуримтлагдсан үр дүн	604,051.82	0
51220	Тайлант үеийн үр дүн	604,051.82	0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>604,051.82</u>	<u>0</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,332,194,170.15	4,158,646,739.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,926,750.15	4,904,739.12
120	Нийтлэг татварын бус орлого	3,926,750.15	4,904,739.12
120002	Хүүгийн орлого	3,926,750.15	9,309.95
120009	Бусад орлого		4,895,429.17
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,328,267,420.00	4,153,742,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	9,212,721,420.00	4,038,196,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	9,212,721,420.00	4,038,196,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,331,859,685.18	4,159,250,790.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,331,859,685.18	4,159,250,790.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,850,000.00	2,400,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,850,000.00	2,400,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,850,000.00	2,400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,329,009,685.18	4,156,850,790.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,302,770,047.95	3,969,755,922.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	9,302,770,047.95	3,969,755,922.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,239,637.23	187,094,868.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,239,637.23	187,094,868.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>334,484.97</u>	<u>-604,051.82</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>334,484.97</u>	<u>-604,051.82</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	9,338,635,392.20	4,160,973,013.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,367,972.20	7,231,013.12
120	Нийтлэг татварын бус орлого	10,367,972.20	7,231,013.12
120002	Хүүгийн орлого	3,926,750.15	9,309.95
120009	Бусад орлого	6,441,222.05	7,221,703.17
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,328,267,420.00	4,153,742,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	9,212,721,420.00	4,038,196,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	9,212,721,420.00	4,038,196,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	9,338,300,907.23	4,161,577,064.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,338,300,907.23	4,161,577,064.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,850,000.00	2,400,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,850,000.00	2,400,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,850,000.00	2,400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,335,450,907.23	4,159,177,064.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,309,211,270.00	3,972,082,196.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	9,309,211,270.00	3,972,082,196.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,239,637.23	187,094,868.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,239,637.23	187,094,868.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	604,051.00	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	604,051.00	-

2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,153,742.00	3,974,482,196
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,153,742.00	3,974,482,196
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,153,742.00	3,974,482,196
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213204	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4,153,742.000	3,974,482,196
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,153,742.000	3,974,482,196
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		
131007	Улсын төсвөөс санхүүжих	4038,196,000	3,858,936,196
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		
132001	Орон нутгийн төсвөөс	115,546,000	115,546,000

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газрын Нийгмийн халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05/24 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газрын Нийгмийн халамжийн сан нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэх, үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг.

“Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангах” гэсэн зорилгын хүрээнд Засгийн газрын бодлого, шийдвэр, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд "Өрх бүрд ажлын байр" хөтөлбөрийг хэрэгжүүлж, өрхийн орлого нэмэгдүүлэн, ажилгүйдлийн түвшинг бууруулах, мэргэжлийн боловсрол олгох, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтод бүлгийн өрх иргэдэд түргэн шуурхай хүргэж ажиллах зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2020, 2021 оны хагас жилийн Хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээнд өрх, иргэдийг хамруулсан байдал, зарцуулсан хөрөнгө, үр дүнд урьдчилан сэргийлэх шалгалтыг 2021 оны 05 дугаар сарын 25-наас 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх гүйцэтгэсэн байна. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 9 заалт бүхий хугацаатай албан шаардлага өгсөн байна. Дээрх шалгалтын мөрөөр гүйцэтгэл сайжруулах ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжүүлсэн.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газрын Нийгмийн халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 9,331.8 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 186.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 79.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газрын Нийгмийн халамжийн сангийн 2021 онд Улсын төсвөөс 4,038.2 сая , орон нутгийн төсвөөс 115.5 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Нийгмийн халамжийн сан нь нийтээр хүлээн зөвшөөрсөн стандарт болон “Нийгмийн халамжийн тухай хууль”, Ахмадын настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Олон хүүхэд төрүүлсэн эхийг урамшуулах тухай хууль, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль, Монгол улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай хуулиар давхар зохицуулагдаж байна.

Нийгмийн халамжийн сангаас 2021 онд тэтгэвэр 1256 иргэнд 920.6, асаргааны тэтгэмж 1135 иргэнд 932.6, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 1035 иргэнд 734.5, ахмад настны хөнгөлөлтөд 4986 иргэнд 313.6, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтөд 730 иргэнд 186.4, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 5739 иргэнд 752.6, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж 29 иргэнд 34.8, ОНОТХҮ-нд 270 иргэнд 80.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжих 10,476.3 сая, орон нутгийн төсвөөс 192.1 сая, нийт 10,668.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн төсвийн төслийг 6,514.7 сая төгрөгөөр бууруулж, 4,153.7 сая төгрөгөөр баталсан байна. Санхүүжилт буурсан нь зарим тэтгэвэр, тэтгэмжийн олголтыг иргэний данс руу шилжүүлж байгаатай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэх 4,038,2, орон нутгийн төсвөөс санхүүжих 115.5, нийт 4,153.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас улсын төсвөөс санхүүжих 3,859.0, орон нутгийн төсвөөс санхүүжих 115,5, нийт 3,974.5 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 179.2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа "Цахим Монгол" хөтөлбөрийн хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээ үе шаттай цахимд шилжиж байна. Тухайн онд 6 төрлийн үйлчилгээ цахимд шилжсэн, үүнтэй холбоотойгоор санхүүжилт 6,514.7 сая төгрөгөөр буурсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 144 мэдээлэл, хугацаа болоогүй мэдээлэл 2, хугацаа хоцроосон мэдээлэл, мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй асуудал илэрсэнгүй.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн.